



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

2020 оны 08 дугаар сарын 12
№30 /1132/

**Монгол Улсын
хууль**

**Санхүүжилтийн хэлэлцээр
соёрхон батлах тухай**

**Монгол Улсын
Засгийн Газрын
тогтоол**

**Журам батлах
тухай**

**Монгол Улсын
Үндсэн хуулийн
цэцийн тогтоол**

**Монгол Улсын Их Хурлын
сонгуулийн тухай хуулийн зарим
заалт Үндсэн хуулийн холбогдох
заалтыг зөрчсөн эсэх маргааныг
эцэслэн шийдвэрлэсэн тухай**

ГАРЧИГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

363. Санхүүжилтийн хэлэлцээр
соёрхон батлах тухай 1637

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

364. Төрийн захиргааны албан тушаалын
зэрэг дэв олгох тухай Дугаар 76 1638

365. Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн
албан тушаалд томилох тухай Дугаар 77 1639

366. Шүүхийн ёс зүйн хорооны гишүүнээр
томилох тухай Дугаар 78 1639

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

367. Журам батлах тухай Дугаар 37 1640

368. Журам батлах тухай Дугаар 50 1643

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ТОГТООЛ

369. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн
тухай хуулийн зарим заалт Үндсэн хуулийн
холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг
Эцэслэн шийдвэрлэсэн тухай Дугаар 01 1651

МОНГОЛ УЛС ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ

370. Санхүүжилтийн хэлэлцээр (“Улаанбаатар хотын
дулаан хангамжийн үр ашгийг нэмэгдүүлэх” төсөл) 1662

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны 05 дугаар
сарын 14-ний өдөр

Улаанбаатар
хот

**САНХҮҮЖИЛТИЙН ХЭЛЭЛЦЭЭР
СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Монгол Улс болон Олон улсын хөгжлийн ассоциаци хооронд 2020 оны 04 дүгээр сарын 27-ны өдөр байгуулсан “Улаанбаатар хотын дулаан хангамжийн үр ашгийг нэмэгдүүлэх” төслийн Санхүүжилтийн хэлэлцээрийг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2020 оны 05 дугаар
сарын 29-ний өдөр

Дугаар 76

Улаанбаатар
хот

Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв олгох тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, Төрийн албаны тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2.1 дэх заалт, Монгол Улсын Их Хурлын 2019 оны 21 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журам”-ын 2.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Хавсралтад дурдсан төрийн захиргааны албан хаагчдад төрийн захиргааны албан тушаалын тэргүүн түшмэлийн зэрэг дэв олгосугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ХАЛТМААГИЙН
БАТТУЛГА**

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2020 оны
05 дугаар сарын 29-ний өдрийн 76 дугаар
зарлигийн хавсралт

ТЭРГҮҮН ТҮШМЭЛИЙН ЗЭРЭГ ДЭВ ОЛГОХ ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИД

№	Овог, нэр	Эрхэлж буй ажил	Албан тушаалын зэрэглэл	Олгох зэрэг дэв
1	Тогмидын Гантөмөр	Улаанбаатар хотын ерөнхий менежер бөгөөд Захирагчийн ажлын албаны дарга	ТЗ-14	Тэргүүн түшмэлийн тэргүүн зэрэг
2	Сандагийн Магнайсүрэн	Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга	ТЗ-15	Тэргүүн түшмэлийн дэд зэрэг
3	Цэвэлсодномын Ганхүү	Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын дарга	ТЗ-14	Тэргүүн түшмэлийн дэд зэрэг
4	Одонмажигийн Амгаланбаатар	Шүүхийн ерөнхий зөвлөлийн Гүйцэтгэх нарийн бичгийн дарга	ТӨ-IVA	Тэргүүн түшмэлийн дэд зэрэг
5	Жанлавын Наранпүрэв	Улсын Дээд шүүхийн Тамгын газрын дарга	AA-1	Тэргүүн түшмэлийн дөтгөөр зэрэг



6	Халзанхүүгийн Батбилэг	Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга	T3-15	Тэргүүн түшмэлийн дөтгөөр зэрэг
7	Доржготовын Ууганбаатар	Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах комиссын Нарийн бичгийн дарга	T3-15	Тэргүүн түшмэлийн дөтгөөр зэрэг

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2020 оны 06 дугаар
сарын 02-ны өдөр

Дугаар 77

Улаанбаатар
хот

Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн албан тушаалд томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин нэгдүгээр зүйлийн 2, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Улсын дээд шүүхийн санал болгосноор Дамдины Ганзоригийг Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн албан тушаалд томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ХАЛТМААГИЙН
БАТТУЛГА**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2020 оны 06 дугаар
сарын 02-ны өдөр

Дугаар 78

Улаанбаатар
хот

Шүүхийн ёс зүйн хорооны гишүүнээр томилох тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, Шүүхийн захиргааны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Дашпунцагийн Эрдэнэчимэгийг Шүүхийн ёс зүйн хорооны гишүүнээр томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ХАЛТМААГИЙН
БАТТУЛГА**



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2020 оны 01 дүгээр
сарын 29-ний өдөр

Дугаар 37

Улаанбаатар
хот

Журам батлах тухай

Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 19.5-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Эрүүл мэндийг дэмжих сангийн хөрөнгийг зарцуулах, хяналт тавих журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.

2. Эрүүл мэндийг дэмжих санд олгох хөрөнгийн эх үүсвэрийг улсын төсөвт жил бүр тусгаж байхыг Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, Сангийн хөрөнгийн зарцуулалт, үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн сайд Д.Сарангэрэлд тус тус даалгасугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Дүрэм, журам батлах тухай” Засгийн газрын 2017 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн 82 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

У.ХҮРЭЛСҮХ

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД

Д.САРАНГЭРЭЛ

Засгийн газрын 2020 оны
37 дугаар тогтоолын хавсралт

ЭРҮҮЛ МЭНДИЙГ ДЭМЖИХ САНГИЙН ХӨРӨНГИЙГ ЗАРЦУУЛАХ, ХЯНАЛТ ТАВИХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 19.1-д заасан “Эрүүл мэндийг дэмжих сан” (цаашид “Сан” гэх)-гийн хөрөнгийг зарцуулах, түүнд хяналт тавихтай холбогдон үүсэх харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.2. Сан нь үйл ажиллагаандаа Засгийн газрын тусгай сангийн тухай хууль, Төсвийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, энэхүү журмыг баримтална.

Хоёр. Сангийн хөрөнгийн эх үүсвэр, зарцуулалт

2.1. Сангийн хөрөнгө нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ:

2.1.1. улсын төсвийн хөрөнгө;

2.1.2. хандив, тусламж;
2.1.3. архи, согтууруулах ундааны онцгой албан татварын 1 хувь;

2.1.4. эмийн импортын гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татварын 2 хувь;

2.1.5. тамхины онцгой албан татварын 2 хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгө.

2.2. Сангийн хөрөнгийг Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 19.3 дахь хэсэгт заасан дараах арга хэмжээг санхүүжүүлэхэд зарцуулна:

2.2.1. халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх;
2.2.2. халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх;
2.2.3. орчны эрүүл мэндийг хамгаалах;
2.2.4. осол, гэмтлээс урьдчилан сэргийлэх, эрүүл, аюулгүй амьдралын орчныг бүрдүүлэх;

2.2.5. сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалах, архи, тамхи, мансууруулах бодисын хорт нөлөөллөөс сэргийлэх;

2.2.6. эмийн зохистой хэрэглээг сурталчлан таниулах;
2.2.7. эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, эрүүл мэндийн байгууллагын ил тод байдал, хариуцлагыг дээшлүүлэх.

2.3. Сангийн хөрөнгөөс аливаа татаас, урамшуулал, тусламж олгохыг хориглоно.

Гурав. Сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөр арга хэмжээг шалгаруулах, санхүүжүүлэх

3.1. Сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, хөтөлбөр, арга хэмжээний санал нь энэ журмын 2.2-т заасан чиглэлээс гадна дараах шаардлагад нийцсэн байна:

3.1.1. Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлогын нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр дэвшүүлсэн зорилтод нийцсэн;

3.1.2. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр тусгасан зорилтод нийцсэн;

3.1.3. төсөл, хөтөрбөр, арга хэмжээ хэрэгжих боломжтой, үр дүнгийн урьдчилсан төсөөлөлтэй;

3.1.4. төсөл хэрэгжүүлэгчийн хүний нөөц, санхүүгийн чадавхын талаарх мэдээллийг хавсаргасан;



3.1.5. төслийн төсөвт үзүүлэх нөлөөлөл, санхүүгийн тооцоололтой.

3.2. Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь Сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөр, арга хэмжээний талаар хэвлэл, мэдээллийн хэрэгсэл, цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлнэ.

3.3. Иргэн, хуулийн этгээд нь Сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөр, арга хэмжээний талаарх хүсэлтийг тухайн төсвийн жилийн 1 дүгээр сарын 1-ний өдрөөс 1 дүгээр сарын 20-ны өдрийг хүртэл, 6 дугаар сарын 1-ний өдрөөс 6 дугаар сарын 20-ны өдрийг хүртэл хугацаанд эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад бичгээр тус тус хүргүүлнэ.

3.4. Сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөр, арга хэмжээг сонгон шалгаруулах Ажлын хэсгийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоо болон холбогдох салбар зөвлөлийн төлөөллөөс оролцуулан эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний тушаалаар байгуулна.

3.5. Энэ журмын 3.4-т заасан ажлын хэсэг нь Сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлэх хүсэлтийг хүлээн авч дууссан хугацаанаас хойш ажлын 30 хоногт багтаан сонгон шалгаруулна.

3.6. Сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөр, арга хэмжээний санхүүжилтийг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрийг үндэслэн дараах хэлбэрээр олгоно:

3.6.1. урьдчилгаа олгож гүйцэтгэлээр санхүүжүүлэх буюу тухайн ажил, үйлчилгээний онцлог, шаардагдах хөрөнгийн хэмжээтэй уялдуулан үе шаттайгаар санхүүжүүлэх;

3.6.2. шууд санхүүжүүлэх буюу ажил, үйлчилгээг гүйцэтгэсний дараа санхүүжилтийг бүрэн хэмжээгээр нэг удаа олгох.

3.7. Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнээс эрх олгосон удирдах албан тушаалтан Сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлэх иргэн, хуулийн этгээдтэй холбогдох гэрээг байгуулж, хяналт тавина. Гэрээнд дараах зүйлийг заавал тусгана:

3.7.1. үйл ажиллагааны явцын тайлан ирүүлэх хугацаа;

3.7.2. Сангаас санхүүжилт олгох хэлбэр болон хуваарь;

3.7.3. санхүүгийн тайлан ирүүлэх хугацаа;

3.7.4. ажлын үр дүн, гүйцэтгэлийн тайлан ирүүлэх хугацаа.

3.8. Сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэх шийдвэр гаргах албан тушаалтан ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан журмын дагуу тухай бүр авч хэрэгжүүлнэ.

Дөрөв. Сангийн хөрөнгийн тайлагнал, ил тод байдал, түүнд тавих хяналт

4.1. Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 24.1-д заасны дагуу Сангийн хөрөнгийн зарцуулалтын тайланг хагас, бүтэн жилээр гаргаж, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлд заасан тайланд тусган санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

4.2. Сангийн хөрөнгийн зарцуулалтын тайланд Төрийн аудитын тухай хуульд заасны дагуу аудит хийж, дүгнэлт гаргана.

4.3. Сангийн хөрөнгийн жилийн эцсийн зарцуулалтын тайланг аудитын дүгнэлтийн хамт уг тайлан гарснаас хойш 20 хоногийн дотор байгууллагын шилэн данс, цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлнэ.

Тав. Бусад

5.1. Сангийн хөрөнгийг хууль тогтоомж, эрх бүхий байгууллагын шийдвэрт зааснаас бусад зориулалтаар болон хэтрүүлэн зарцуулахыг хориглоно.

5.2. Сангийн хөрөнгийг батлагдсан төсвөөс хэтрүүлэх, хуульд зааснаас өөр зориулалтаар ашиглах, зарцуулахыг хориглоно.

5.3. Сангийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулсан, ашигласан албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2020 оны 02 дугаар
сарын 04-ний өдөр

Дугаар 50

Улаанбаатар
хот

Журам батлах тухай

Иргэний тэтгэвэр барьцаалсан зээлийн төлбөрийг төрөөс нэг удаа төлөх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:



1. “Иргэний тэтгэвэр барьцаалсан зээлийн төлбөрийг төрөөс нэг удаа төлөх тухай хуулийг хэрэгжүүлэх журам”-ыг 1 дүгээр хавсралт, “Иргэний тэтгэвэр барьцаалсан зээлийн төлбөрийг төрөөс нэг удаа төлөх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийг хэрэгжүүлэх журам”-ыг 2 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд С.Чинзоригт даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

У.ХҮРЭЛСҮХ

**ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН САЙД**

С.ЧИНЗОРИГ

Засгийн газрын 2020 оны
50 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

ИРГЭНИЙ ТЭТГЭВЭР БАРЬЦААЛСАН ЗЭЭЛИЙН ТӨЛБӨРИЙГ ТӨРӨӨС НЭГ УДАА ТӨЛӨХ ТУХАЙ ХУУЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэ журмаар Иргэний тэтгэвэр барьцаалсан зээлийн төлбөрийг төрөөс нэг удаа төлөх тухай хууль (цаашид “Хууль” гэх)-ийн үйлчлэлд хамаарах Монгол Улсын иргэн (цаашид “Зээлдэгч” гэх)-ий 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуусталх хугацааны тэтгэвэр барьцаалсан зээл (цаашид “зээл” гэх)-ийн үлдэгдэл төлбөрийн тодорхой хэсэг (цаашид “зээлийн төлбөр” гэх)-ийг төрөөс нэг удаа төлөх дүн, түүнийг төлөх, энэхүү арга хэмжээний санхүүжилтийн эх үүсвэр, зээлийн төлбөрийн үүрэг дуусгавар болох, зээлийн гэрээг шинэчлэх, мэдээлэл солилцох, үйл ажиллагааны хяналт, тайлагналттай холбоотой харилцааг зохицуулна.

Хоёр. Журмын хамрах хүрээ

2.1. Энэ журамд Хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1, 4.2 дахь хэсэгт заасан Монгол Улсын иргэн хамаарна.

Гурав. Зээлийн төлбөрийн дүн, түүнийг төлөх

3.1. Хуулийн 4 дүгээр зүйлийн 4.4 дэх хэсэгт заасны дагуу зээлийн төлбөр нь 6 000 000 (зургаан сая) төгрөг ба түүнээс доош дүнтэй байна.

3.2. Зээлийн төлбөрийг Хуулийн 4 дүгээр зүйлийн 4.4 дэх хэсэгт заасны дагуу төлнө.

3.3. Зээлдэгч 2 ба түүнээс дээш төрлийн тэтгэвэр (тэжээгчээ алдсаны тэтгэвэр хамаарахгүй) авдаг бөгөөд тэтгэвэр тус бүрийг барьцаалан зээл авсан бол зээлийг хамгийн бага дүнтэйгээс эхлэн төлнө. Энэ тохиолдолд нийт төлөх зээлийн төлбөрийн хэмжээ энэ журмын 3.1-д заасан дүнгээс хэтрэхгүй байна.

3.4. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу тэжээгчээ алдсаны тэтгэврийг адил хэмжээгээр хуваан авдаг тэтгэвэр авагч зээлтэй бол зээлдэгч тус бүрийн зээлийн төлбөр нь энэ журмын 3.1-д заасан дүнгээс хэтрэхгүй байна.

Дөрөв. Санхүүжилтийн эх үүсвэр

4.1. Зээлийн төлбөрийг төлөх санхүүжилтийн эх үүсвэр нь Хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасны дагуу “Эрдэнэс Монгол” ХХК (цаашид “компани” гэх)-иас гаргасан үнэт цаас байна.

4.2. Хөгжлийн банк “Эрдэнэс Силвер Ресурс” ХХК-ийн эзэмшлийн Салхитын мөнгө, алтны ордыг эдийн засгийн эргэлтэд оруулсан орлогоос төрд ногдох өгөөж, тус ордод хамаарах Ашигт малтмалын тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1 дэх хэсэгт заасан баримт бичиг, эд хөрөнгийг барьцаалан энэ журмын 4.1-д заасан үнэт цаасанд баталгаа гаргана.

4.3. Компани тэтгэвэр барьцаалсан зээлийн үүргийг энэ журмын 4.1-д заасны дагуу гаргасан үнэт цаасаар төлөх гэрээг холбогдох банктай байгуулна. Энэ гэрээ байгуулах нөхцөлийг бүрдүүлэх арга хэмжээг эрх бүхий байгууллагууд зохих журмын дагуу авч хэрэгжүүлнэ.

4.4. Монголбанк Хуулийн 5 дугаар зүйлийн 5.4-т заасныг үндэслэн компанийн гаргах үнэт цаасны өгөөжийг нэмэгдүүлэх зорилгоор санхүүгийн хэрэгсэл ашиглан хөрөнгийн хямд эх үүсвэр бий болгож, үнэт цаасыг худалдан авах үйл ажиллагааг 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн дотор гүйцэтгэнэ.

4.5. Компани өөрийн охин компани “Эрдэнэс Силвер Ресурс” ХХК-ийн эзэмшлийн Салхитын мөнгө, алтны ордыг эдийн засгийн эргэлтэд оруулах үйл ажиллагаанд хяналт тавих замаар үнэт цаасны тодорхой хэсгийг мөнгөжүүлэн эргэн төлөх үйл ажиллагааг Монголбанк, банктай хамтран гүйцэтгэнэ.

4.6. Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв ХХК нь үнэт цаас эзэмшигчийн бүртгэлийн цахим сан үүсгэж, холбогдох банкны эзэмшиж буй үнэт цаасны талаар мэдээлэл авах нөхцөлийг бүрдүүлэх, компанийн гаргах үнэт цаасыг бүртгэх, хөтлөх ажлыг үнэ төлбөргүй хийж гүйцэтгэнэ.



Тав. Зээлийн төлбөрийн үүрэг дуусгавар болох, зээлийн гэрээг шинэчлэх

5.1. Энэ журмын 4.3-т заасан гэрээнд хоёр тал гарын үсэг зурж баталгаажуулснаар зээлдэгчийн зээлийн төлбөрийн үүрэг дуусгавар болсон тэтгэвэр авагчид дараа сарын тэтгэврийг бүрэн олгоно. Энэ журмын 3-т заасны дагуу төрөөс зээлийн төлбөр төлөх дүнг банк зөвхөн зээлдэгчийн зээлийн төлбөрийг төлж барагдуулахад зарцуулна.

5.2. Банк 6 000 000 (зургаан сая) төгрөг болон түүнээс доош дүн бүхий зээлийн төлбөрийн үлдэгдэлтэй зээлдэгчийн зээлийн гэрээг дуусгавар болгож, 6 000 000 (зургаан сая) төгрөгөөс дээш зээлийн төлбөрийн үлдэгдэлтэй зээлдэгчтэй зээлийн төлбөр, бусад нөхцөлийг тохирсон гэрээг шинэчлэн байгуулна.

Зургаа. Мэдээлэл солилцох

6.1. Хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасан мэдээллийг нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага (цаашид “НДЕГ” гэх) харилцагч банканд хүргүүлнэ.

6.2. Хуулийн 6 дугаар зүйлийн 6.2-т заасан мэдээллийг банк баталгаажуулан НДЕГ-т албан бичгээр хүргүүлнэ.

6.3. НДЕГ энэ журмын 6.2-т заасан мэдээллийг банк бүрээр гаргаж компанид хүргүүлнэ.

6.4. Энэ журмын 6.2-т заасан мэдээлэлд тэтгэвэр авагчийн овог нэр, регистрийн дугаар, сарын тэтгэврийн хэмжээ, харьяалагдах нийгмийн даатгалын хэлтсийн нэр, 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар тэтгэврийн зээлийн үлдэгдэл төлбөр, хүүгийн хувь хэмжээ, анх олгосон зээлийн дүн, он, сар, өдөр, дансны дугаар зэрэг мэдээллийг тусгасан байна. Энэ мэдээллийн маягыг НДЕГ батална.

Долоо. Хяналт, тайлагналт, бусад

7.1. Журмын хэрэгжилтэд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам хяналт тавьж, ажлын үр дүнг Улсын Их Хуралд 2020 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд багтаан тайлагнана.

7.2. Хууль болон энэ журмыг зөрчсөн гэм буруутай этгээдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

**ИРГЭНИЙ ТЭТГЭВЭР БАРЬЦААЛСАН ЗЭЭЛИЙН ТӨЛБӨРИЙГ
ТӨРӨӨС НЭГ УДАА ТӨЛӨХ ТУХАЙ ХУУЛИЙГ ДАГАЖ МӨРДӨХ
ЖУРМЫН ТУХАЙ ХУУЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэ журмаар Иргэний тэтгэвэр барьцаалсан зээлийн төлбөрийг төрөөс нэг удаа төлөх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль (цаашид “Хууль” гэх)-ийн үйлчлэлд хамаарах Монгол Улсын иргэн (цаашид “иргэн” гэх)-нд эзэмшүүлэх үнэт цаасны дүн, Салхитын мөнгө, алтны ордыг эдийн засгийн эргэлтэд оруулсан орлогоос төрд ногдох өгөөжийг барьцаалан үнэт цаас (цаашид “Үнэт цаас” гэх) гаргах, мэдээлэл солилцох, бүртгэх, олгох, тооцоо хийж тайлагнах, үнэт цаасыг мөнгөжүүлж иргэнд төлөх, нийгмийн даатгалын сангийн хөрөнгийг арилжааны банк (цаашид “банк” гэх)-анд байршуулахтай холбоотой харилцааг зохицуулна.

Хоёр. Журмын хамрах хүрээ

2.1. Энэ журамд Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1, 2, Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан тэтгэвэр авагч, 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөс өмнө тэтгэвэр авах эрх нь дуусгавар болоогүй Монгол Улсын дараах иргэн хамаарна:

2.1.1. Хуулийн 1 дүгээр зүйлд заасны дагуу 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар тэтгэвэр барьцаалсан зээл (цаашид “зээл” гэх) аваагүй, зээл авсан боловч 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар зээлээ бүрэн төлсөн;

2.1.2. Хуулийн 4 дүгээр зүйлд заасан.

2.2. Энэ журамд дараах тэтгэвэр авагч, иргэн хамаарахгүй:

2.2.1. 2019 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар хөдөлмөрийн чадвар алдсан хугацаа дуусаж, уг хугацааг сунгуулаагүй тахир дутуугийн тэтгэвэр авагч;

2.2.2. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 15 дугаар зүйл, Нийгмийн даатгалын сангаас



олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн 12 дугаар зүйл, Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 24 дүгээр зүйлд заасны дагуу тэжээгчээ алдсаны тэтгэвэр нь 2019 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар зогссон тэтгэвэр авагч;

2.2.3. 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс өмнө тэтгэвэр тогтоолгох эрхээ хэрэгжүүлээгүй иргэн.

2.3. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1, 11.2 дахь хэсэгт заасан тахир дутуугийн тэтгэвэр авагчид энэ журмын 2.2.1 дэх заалт хамаарахгүй.

Гурав. Эзэмшүүлэх үнэт цаасны дүн

3.1. Иргэнд үнэт цаасыг дараах дүнгээр эзэмшүүлнэ:

3.1.1. Энэ журмын 2.1.1-д заасан иргэнд 1 000 000 (нэг сая) төгрөгийн;

3.1.2. Энэ журмын 2.1.2-т заасан иргэнд зээлийн үлдэгдэл төлбөр болон 1 000 000 (нэг сая) төгрөгийн зөрүү дүнгээр.

3.2. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу тэжээгчээ алдсаны тэтгэврийг адил хэмжээгээр хуваан авдаг тэтгэвэр авагчийн хувьд хөдөлмөрийн чадваргүй иргэний тооноос хамааруулан хувь тэнцүүлэн үнэт цаас эзэмшүүлэх дүнг тодорхойлно.

Дөрөв. Мэдээлэл солилцох

4.1. Энэ журмын 2.1.2-т заасан иргэний мэдээллийг нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага (цаашид “НДЕГ” гэх) харилцагч банканд өгнө.

4.2. Банк энэ журмын 4.1-д заасан мэдээллийг баталгаажуулан НДЕГ-т албан бичгээр ирүүлнэ.

4.3. НДЕГ энэ журмын 2.1.1, 4.2-т заасан мэдээллийг банк бүрээр нэгтгэн гаргаж төрийн өмчит “Эрдэнэс Монгол” ХХК (цаашид “компани” гэх)-нд хүргүүлнэ.

4.4. Энэ журмын 4.3-т заасан мэдээлэлд тэтгэвэр авагчийн овог нэр, регистрийн дугаар, сарын тэтгэврийн хэмжээ, харьяалагдах нийгмийн

даатгалын хэлтсийн нэр, 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар тэтгэврийн зээлийн үлдэгдэл төлбөр, хүүгийн хувь хэмжээ, анх олгосон зээлийн дүн, он, сар, өдөр, дансны дугаар, тэтгэвэр тогтоосон огноо, тэтгэврийн төрөл зэрэг мэдээллийг тусгасан байна. Энэ мэдээллийн маягтыг НДЕГ батална.

**Тав. Үнэт цаас гаргах, бүртгэх, хүргүүлэх,
тооцоо хийж тайлагнах**

5.1. Компани холбогдох хуульд заасны дагуу нууцлалын шаардлага хангасан үнэт цаасыг Хуулийн 2 дугаар зүйлд заасан нөхцөлөөр Хуульд заасан үйл ажиллагаанд зарцуулах зорилгоор гаргана. Үнэт цаасны загварыг компани батална.

5.2. Энэ журмын 5.1-д заасан үнэт цаасыг эзэмшигч тэтгэвэр авагч нь үнэт цаасыг гуравдагч этгээдэд худалдан борлуулах, аливаа бусад хэлбэрээр шилжүүлэхгүй ба зөвхөн өвлүүлэх эрхтэй.

5.3. Компани энэ журмын 4.4-т заасан мэдээлэлд үндэслэн Компанийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2-т заасны дагуу үнэт цаас эзэмшигчдийн бүртгэлийг үнэт цаасны хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэгч “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-иар үнэт төлбөргүй гүйцэтгүүлнэ.

5.4. “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК нь үнэт цаас эзэмшигчдийн бүртгэлийн цахим сан үүсгэж, энэ журмын 2.1-д заасан иргэн өөрийн эзэмшиж буй үнэт цаасны талаар мэдээлэл авах нөхцөлийг бүрдүүлсэн байна.

5.5. Хөгжлийн банк хууль тогтоомжид нийцүүлэн энэ журмын 5.1-д заасан үнэт цаасанд баталгаа гаргана.

5.6. Компани энэ журмын 5.1-д заасан үнэт цаасыг НДЕГ-т ирүүлнэ.

5.7. НДЕГ холбогдох үнэт цаасыг тэтгэвэр авагчид олгох ажлыг хариуцан гүйцэтгэнэ.

5.8. Компани, “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК, НДЕГ нь эзэмшүүлсэн үнэт цаасны тооцоо, тайланг хийж баталгаажуулна.

Зургаа. Үнэт цаасыг мөнгөжүүлэх, иргэнд төлөх

6.1. Компани хуулийн 1, 4 дүгээр зүйлд заасан үнэт цаасыг 2021 оны 05 дугаар сарын 21-ний өдрөөс эхлэн мөнгөжүүлж, эх үүсвэрийг холбогдох



төрийн байгууллагуудтай зөвшилцсөний үндсэн дээр иргэдэд төлөх ажлыг Монголбанк, банктай хамтран зохион байгуулна.

6.2. Монголбанк хуульд заасан нөхцөл журмын дагуу Компаниас гаргах үнэт цаасыг худалдан авахад дэмжлэг үзүүлнэ.

Долоо. Нийгмийн даатгалын сангийн мөнгөн хөрөнгийг банканд байршуулах

7.1. Хуулийн 5 дугаар зүйлд заасны дагуу НДЕГ нь нийгмийн даатгалын сангийн мөнгөн хөрөнгөөс хөнгөлөлттэй хүүтэй хадгаламжийг банканд байршуулж болно. Шаардлагатай тохиолдолд Монголбанкийг санхүүгийн зуучлагчийн чиг үүрэгтэйгээр оролцуулж, хамтран зохион байгуулна.

7.2. НДЕГ байршуулах хөрөнгийн хэмжээг банк тус бүрээр гарган мөнгөн хадгаламжийн гэрээ байгуулна. Байршуулах хөрөнгийн хэмжээ хүрэлцэхгүй тохиолдолд дүнг зээлийн үлдэгдэл төлбөрөөс хамааруулан хувь тэнцүүлэн, хүүг дахин бууруулах замаар шийдвэрлэнэ.

7.3. Энэ журмын 7.1-д заасан хадгаламжийг Иргэний тэтгэвэр барьцаалсан зээлийн төлбөрийг төрөөс нэг удаа төлөх тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4 дэх хэсэгт заасны дагуу компанийн гаргасан үнэт цаасыг Монголбанк эзэмших хүртэл хугацаа буюу 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл байршуулна.

7.4. Банканд байршуулах мөнгөн хадгаламжийн дүн, хүүгийн хэмжээ, мөнгөн хадгаламжийн гэрээний загварыг Монголбанк, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны саналыг үндэслэн Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл тогтооно.

7.5. НДЕГ нь энэ журмын 7.1-д заасны дагуу банканд хадгаламж байршуулахдаа Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2018 оны 08 дугаар тогтоолоор баталсан нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдэл, хуримтлалын сангийн хөрөнгийг арилжааны банканд мөнгөн хадгаламж хэлбэрээр байршуулах журам, гэрээний загварыг мөрдөхгүй.

Найм. Бусад

8.1. Энэ журмыг зөрчсөн гэм буруутай этгээдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ТОГТООЛ

2020 оны 06 дугаар
сарын 03-ны өдөр

Дугаар 01

Улаанбаатар
хот

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн зарим заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг эцэслэн шийдвэрлэсэн тухай

Үндсэн хуулийн цэцийн
хуралдааны танхим 10.30 цаг

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн их суудлын хуралдааныг Үндсэн хуулийн цэцийн дарга Н.Чинбат даргалж, Үндсэн хуулийн цэцийн гишүүн Ш.Цогтоо, Д.Солонго, Д.Одбаяр /илтгэгч/, Б.Буяндэлгэр, Г.Туулхүү, Ш.Солонго, Ц.Нанзаддорж, Г.Баясгалан нарын бүрэлдэхүүнтэй, хуралдааны нарийн бичгийн даргаар Б.Мөнхгэрэлийг оролцуулан Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхимд нээлттэй хийв.

Үндсэн хуулийн цэцийн их суудлын хуралдаанаар Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт уг хуулийн 28 дугаар зүйлийн 28.3.1 дэх заалтад зааснаас өөр хугацаа тогтоосон нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 9, 10 дахь заалт, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг дахин хянан эцэслэн шийдвэрлэж, мөн Улсын Их Хурлын 2020 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн “Үндсэн хуулийн цэцийн 2020 оны 02 дугаар дүгнэлтийн тухай” 33 дугаар тогтоолыг хянан хэлэлцэв.

Нэг. Нийслэлийн Сүхбаатар дүүргийн 2 дугаар хорооны оршин суугч, иргэн Р.Гончигдорж, Сонгинохайрхан дүүргийн 5 дугаар хорооны оршин суугч, иргэн Э.Төмөрбаатар нар Үндсэн хуулийн цэцэд хандаж дараах агуулга бүхий мэдээлэл гаргасан байна. Үүнд:

“1. ... Монгол Улсын Их Хурлаас 2019 оны 12 дугаар сарын 20-ны өдөр баталсан Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт “Энэ хуульд заасны дагуу сонгууль товлон зарлахаас өмнө Улсын дээд шүүхэд бүртгүүлсэн нам сонгуульд оролцож, энэ хуульд заасан шаардлага хангасан Монгол Улсын иргэнийг Улсын Их Хурлын гишүүнд нэр дэвшүүлэх эрхтэй.”, мөн зүйлийн 6.3 дахь хэсэгт “Эвсэлд нэгдсэн бүх нам энэ хуулийн 6.1-д заасан шаардлагыг хангасан байна.” гэж тус тус заажээ.

Улс төрийн намын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.6 дахь хэсэгт “... улсын бүртгэлд бүртгүүлснээр нам үйл ажиллагаагаа ... явуулах эрхтэй.” гэж зааснаар Улсын дээд шүүхэд бүртгүүлснээр улс төрийн нам нь үйл ажиллагаа явуулах эрхтэй болдог бөгөөд үндсэн үйл ажиллагаа нь сонгуульд оролцох юм. Гэтэл Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт сонгууль товлон зарлахаас



өмнө Улсын дээд шүүхэд бүртгүүлээгүй боловч энэ хуулийн 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсэгт заасны дагуу санал авах өдрөөс 60 хоногийн өмнө Улсын дээд шүүхэд бүртгэгдсэн нам сонгуульд оролцох хүсэлтээ гаргах эрхийг хязгаарласан байна. Тухайлбал, Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалтад "... сонгох, сонгогдох эрхтэй. ...", мөн зүйлийн 10 дахь заалтад "нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс нам ... байгуулах ... эрхтэй. ...", Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх ... үүргийг иргэнийхээ өмнө хариуцна." гэж заасан байна.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсэгт "Нам, эвсэл Монгол Улсын Үндсэн хууль, энэ хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийг дагаж мөрдөхөө илэрхийлэн, сонгуульд оролцох тухай хүсэлтээ санал авах өдрөөс 60-аас доошгүй хоногийн өмнө Сонгуулийн ерөнхий хороонд ирүүлнэ.", мөн хуулийн 28 дугаар зүйлийн 28.3 дахь хэсэгт "Дараах шаардлагыг хангасан нам, эвслийг бүртгэнэ:" гээд 28.3.1 дэх заалтад "Энэ хуульд заасны дагуу нам, эвсэл сонгуульд оролцохоо илэрхийлэх хугацаанаас өмнө Улсын дээд шүүхэд бүртгүүлсэн;" гэж заасан нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.3 дахь хэсгээс өөрөөр сонгуульд оролцох эрхийг тодорхойлсон байна. Ийм байтал Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.3 дахь хэсгээр Монгол Улсын иргэн Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалтаар олгогдсон "сонгогдох" эрхээ мөн зүйлийн 10 дахь заалтаар олгогдсон эрхээрээ баталгаажуулан, улс төрийн нам байгуулах эрхийнхээ дагуу Улсын Их Хурлын гишүүдийг сонгох сонгуулийн үйл ажиллагаанд оролцох эрхээ хязгаарлуулж байгаа нь Улсын Их Хурал Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан үүргээ зөрчин, Улсын Их Хурлын сонгуульд оролцох эрхийг хязгаарлах замаар иргэдийн Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалтад заасан "сонгогдох" эрхийг зөрчиж байна.

Мөн дам утгаараа нэр дэвших үйл ажиллагаанд намын гишүүнийх нь хувьд ялгаварлан гадуурхсан нөхцөлийг бүрдүүлж, Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 10 дахь заалтад заасан иргэд "... сайн дураараа эвлэлдэн нэгдэх эрхтэй. ... эвлэлдэн нэгдсэний төлөө болон гишүүний нь хувьд хүнийг ялгаварлан гадуурхах ... -ийг хориглоно. ..." гэсэн эрхийг давхар зөрчиж байна. Улсын Их Хурлаас Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан үүргээ зөрчихдөө Үндсэн хуулийн цэцийн 2019 оны 10 дугаар сарын 19-ний 03 дугаар тогтоолоор улс төрийн нам хэзээ байгуулагдсанаас үл хамааран сонгуульд оролцох эрхтэй гэж шийдвэрлэснийг харгалзаж үзээгүй байна. ...

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.3 дахь хэсгүүд нь Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 9, 10 дахь заалт, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийг ... тус тус зөрчжээ гэж бид үзэж байна. ..." гэжээ.

Хоёр. Уг маргаанд холбогдуулан Монгол Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Л.Энх-Амгалангаас Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанд ирүүлсэн харуу тайлбарт:

“1. ... Европын зөвлөлийн Венецийн комиссын 2010 оны 10 дугаар сарын 15, 16-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар “Улс төрийн намын үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтад удирдлага болгох зарчмууд”-ыг хэлэлцэн баталсан бөгөөд үүнд улс төрийн намыг бүртгүүлэхэд зарим нэг шаардлага тавих нь эвлэлдэн нэгдэх эрхийг зөрчсөнд тооцогдохгүй гэж Европын хүний эрхийн шүүхийн шийдвэрүүдэд заасан байдаг. Венецийн комиссын 2010 оны 10 дугаар сарын 15, 16-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар баталсан зарчмын сонгуульд оролцохтой холбогдох хэсгийн 142 дахь хэсэгт улс төрийн нам сонгуульд оролцох боломжид тодорхой шаардлагыг хангасан байж болох тухай заасан байна.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.3 дахь хэсэг нь улс төрийн намыг Улсын дээд шүүхэд бүртгүүлсэн байх хугацааг зөвхөн сонгуульд оролцохоор бүртгүүлэх хүрээнд тавьж буй шаардлага юм. Төрийн үйл хэргийг удирдахад оролцох, төрийн бодлогыг тодорхойлох ажилд оролцохоор сонгуульд өрсөлдөж байгаа улс төрийн нам Улсын Их Хурлын сонгуульд оролцох хүсэлтээ илэрхийлэх нь гэнэтийн, тохиолдлын зүйл байх нь зохимжгүй бөгөөд бодлого, үзэл баримтлалаа тодорхойлоогүй улс төрийн намыг төрийн сонгуульд оролцуулах нь өөрөө сөрөг үр дагаврыг бий болгох эрсдэлтэй гэж үздэг.

Хуульд заасны дагуу сонгуулийн мөрийн хөтөлбөрт орсон зорилт, арга хэмжээ нь Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлалд нийцсэн эсэх болон санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын дүн нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан төсвийн тусгай шаардлагад нийцэж байгаа эсэх талаар төрийн аудитын байгууллагаар хянуулж, дүгнэлт гаргуулсан байх хуулийн хугацаа нь тухайн сонгуулийн жилийн 3 дугаар сарын 25-ны өдөр байхаар хуульд заасан. Ийнхүү хөгжлийн үзэл баримтлалд нийцсэн, төсвийн тусгай шаардлагад нийцэх бодлого тодорхойлох үйл явц нь тодорхой цаг хугацааг шаардах ажил юм.

Энэ хуульд заасны дагуу сонгууль товлон зарлахаас өмнө Улсын дээд шүүхэд бүртгүүлсэн нам сонгуульд оролцож, энэ хуульд заасан шаардлага хангасан Монгол Улсын иргэнийг Улсын Их Хурлын гишүүнд нэр дэвшүүлэх эрхтэй байхаар заасан хуулийн заалт нь улс төрийн намыг бодлого хөтөлбөрөө тодорхойлоход хариуцлагажуулахад чиглэсэн бөгөөд улс төрийн нам нь сонгууль товлон зарлах хугацаанаас өмнө албан ёсоор байгуулагдсан байх шаардлагыг тус хуулиар тогтоосон шаардлагыг хангасан Монгол Улсын иргэнийг нэр дэвшүүлэх шаардлагатай хамт тусгаж өгчээ.



Улсын Их Хурал 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийг баталсан бөгөөд энэ нэмэлт, өөрчлөлтөөр Үндсэн хуулийн Арван ес¹ дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Нам Үндсэн хуулийн арван зургадугаар зүйлийн 10-т заасны дагуу байгуулагдаж, улсын хэмжээний бодлого дэвшүүлж ажиллана.” гэж заажээ. Нам улсын хэмжээний бодлого дэвшүүлж ажиллах, Үндсэн хуулийн заалтыг баримтлан бодлогоо тодорхойлж ажиллахыг Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр онцгойлон зохицуулсныг дурдах нь зүйтэй. ...

Мөн хуулийн 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсэгт “Нам, эвсэл Монгол Улсын Үндсэн хууль, энэ хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийг дагаж мөрдөхөө илэрхийлэн, сонгуульд оролцох тухай хүсэлтээ санал авах өдрөөс 60-аас доошгүй хоногийн өмнө Сонгуулийн ерөнхий хороонд ирүүлнэ.” гэж заасан, мөн хуулийн 38 дугаар зүйлийн 38.6 дахь хэсэгт “Нам, эвсэл нь ээлжит сонгуулийн жилийн 3 дугаар сарын 25-ны өдрөөс өмнө ... сонгуулийн мөрийн хөтөлбөртөө дүгнэлт гаргуулахаар төрийн аудитын дээд байгууллагад хүргүүлнэ.” гэж заасан нь улс төрийн намууд сонгуулийн мөрийн хөтөлбөртөө аудитын дүгнэлт гаргуулах хугацаанаас өмнө, мөнхүү хөтөлбөрийг бэлтгэх, Улс төрийн намын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь хэсэгт зааснаар сонгуульд оролцох мөрийн хөтөлбөрийг намын эрх бүхий байгууллагаар хэлэлцүүлэн шийдвэрлэхээр заасан нь хугацааг зайлшгүй шаардаж байгаа юм.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалтад “... Төрийн байгууллагад ... сонгогдох эрхтэй. ...”, мөн зүйлийн 10 дахь заалтад “нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс нам ... байгуулах ... эрхтэй. ...” байхыг Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.3 дахь хэсгийн заалтууд хязгаарлаж байна гэж үзэхгүй байна. ...” гэсэн байна.

Гурав. Уг маргаанд холбогдуулан Сонгуулийн ерөнхий хорооноос байр сууриа илэрхийлсэн 2020 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн 1/45 дугаар албан бичигт:

“... 3. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт “Энэ хуульд заасны дагуу сонгууль товлон зарлахаас өмнө Улсын дээд шүүхэд бүртгүүлсэн нам сонгуульд оролцож, энэ хуульд заасан шаардлага хангасан Монгол Улсын иргэнийг Улсын Их Хурлын гишүүнд нэр дэвшүүлэх эрхтэй.” гэж, мөн зүйлийн 6.3 дахь хэсэгт “Эвсэлд нэгдсэн бүх нам энэ хуулийн 6.1-д заасан шаардлагыг хангасан байна.” гэж тус тус Улсын Их Хурлын сонгуульд оролцох, нэр дэвшүүлэх эрхээ хэрэгжүүлэхэд улс төрийн нам, эвсэлд тавигдах шаардлагыг тодорхой хуульчилсан байна.” гэжээ.

Дөрөв. Ардчилал Шинэчлэлийн Намаас Үндсэн хуулийн цэцэд хандан ирүүлсэн 2020 оны 3 дугаар сарын 23-ны өдрийн А/08 дугаар албан бичигт:

“Ардчилал шинэчлэлийн нам нь 2019 оны 12 дугаар сарын 18-ны өдөр байгуулагдаж, 2020 оны 02 дугаар сарын 21-ний өдөр Улсын дээд шүүхэд бүртгүүлсэн.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт сонгууль товлон зарлахаас өмнө Улсын дээд шүүхэд бүртгүүлсэн нам Улсын Их Хурлын сонгуульд оролцохоор хуульчилсан боловч тус хуулийн 28 дугаар зүйлийн 28.3 дахь хэсэгт сонгуульд бүртгүүлэх намд тавигдах шаардлагуудыг заасан бөгөөд 28.3.1 дэх заалтад “Энэ хуульд заасны дагуу нам эвсэл сонгуульд оролцохоо илэрхийлэх хугацаанаас өмнө Улсын дээд шүүхэд бүртгүүлсэн байх;” гэж зааснаар хуулийн заалтууд хоорондоо зөрчилдсөн байна.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.3.1 дэх заалтыг баримтлан сонгуульд оролцож болох эсэх тухай Сонгуулийн ерөнхий хорооноос тодруулга авахаар хандсан боловч Сонгуулийн ерөнхий хороонд хууль тайлбарлах эрх байхгүй гэсэн хариуг Сонгуулийн ерөнхий хорооны Ажлын албаны 2020 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн 3-2/29 дүгээр албан бичгээр өгсөн. ...

Манай нам нь хуулийн зөрчилтэй байдал болон, Үндсэн хуулийн цэцийн хуралдааны шийдвэрээс шалтгаалан хуульд заасан графикт ажиллагаануудаа хийж, хариуцсан төрийн байгууллагуудад хандах бололцоогүй болох төдийгүй, Ардчилал Шинэчлэлийн Намын гишүүд Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалтаар олгогдсон “сонгогдох” эрхээ, мөн тус нам нь Улс төрийн намын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.6 дахь хэсгээр олгосон эрхээ эдэлж чадахгүй нөхцөл байдал үүсээд байна. Иймд Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэг дээр үүсгэсэн маргаан хянан шийдвэрлэх Үндсэн хуулийн цэцийн хуралдаанаа хурдавчилсан журмаар хийж өгнө үү.” гэжээ.

Тав. Монгол Улсын Үндсэн хуулийн цэц дээрх маргааныг 2020 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн Дунд суудлын хуралдаанаар хянан хэлэлцэж, 02 дугаар дүгнэлтийг гаргасан болно. Уг дүгнэлтийн үндэслэл хэсэгт:

“1.Монгол Улсын Үндсэн хуулийн Гуравдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ.”, Арван зургадугаар зүйлийн 10 дахь заалтад “нийгмийн болон өөрсдийн



ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс нам, олон нийтийн бусад байгууллага байгуулах, сайн дураараа эвлэлдэн нэгдэх эрхтэй. ... Аль нэгэн нам, олон нийтийн бусад байгууллагад эвлэлдэн нэгдсэний төлөө болон гишүүний нь хувьд хүнийг ялгаварлан гадуурхах, ...-ыг хориглоно. ...”, мөн зүйлийн 9 дэх заалтад “шууд буюу төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан төрийг удирдах хэрэгт оролцох эрхтэй. Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй. ...” хэмээн зааж, Монгол Улсад засгийн бүх эрх ард түмнээс эхтэй болохыг тодорхойлон, Монгол Улсын иргэн улс төрийн намд эвлэлдэн нэгдэж, төрийн эрх барих дээд байгууллага болох Улсын Их Хуралд сонгогдох, мөн намаас нэр дэвшүүлсэн иргэнийг сонгох, эсхүл бие даан нэрээ дэвшүүлэх, ийнхүү дэвшсэн иргэнийг сонгох замаар дээрх эрхээ хэрэгжүүлэх Үндсэн хуулийн боломжийг баталгаажуулан тогтоожээ.

Аливаа улс төрийн нам, эвсэл төрийн эрх барих байгууллагын сонгуульд оролцох, нэр дэвшүүлэх асуудал нь Үндсэн хуулиар баталгаажсан иргэн хүний улс төрийн эрх болон ардчилсан ёс, засгийн бүх эрх ард түмнээс эхтэй байх үзэл санаатай нягт уялдаатай болохыг Үндсэн хуулийн цэцийн 2019 оны 02 дугаар дүгнэлтэд тодорхой тэмдэглэсэн байна.

2. Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин нэгдүгээр зүйлийн 4 дэх хэсэгт “Улсын Их Хурлын сонгуулийн журмыг хуулиар тогтооно. ...” гэж заасны хүрээнд Улсын Их Хурал 2019 оны 12 дугаар сарын 20-ны өдөр Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийг баталжээ. Уг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт “Энэ хуульд заасны дагуу сонгууль товлон зарлахаас өмнө Улсын дээд шүүхэд бүртгүүлсэн нам сонгуульд оролцож, энэ хуульд заасан шаардлага хангасан Монгол Улсын иргэнийг Улсын Их Хурлын гишүүнд нэр дэвшүүлэх эрхтэй.”, 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэгт “Улсын Их Хурал ээлжит сонгуулийг сонгуулийн жилийн 02 дугаар сарын 01-ний өдрөөс өмнө товлон зарлаж, санал авах өдрийг тогтооно.” гэж тус тус хуульчилжээ.

Гэтэл тус хуулийн 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсэгт “Нам, эвсэл ... сонгуульд оролцох тухай хүсэлтээ санал авах өдрөөс 60-аас доошгүй хоногийн өмнө Сонгуулийн ерөнхий хороонд ирүүлнэ.”, 28 дугаар зүйлийн 28.3 дахь хэсэгт “Дараах шаардлагыг хангасан нам, эвслийг бүртгэнэ:” гээд 28.3.1 дэх заалтад “Энэ хуульд заасны дагуу нам, эвсэл сонгуульд оролцохоо илэрхийлэх хугацаанаас өмнө Улсын дээд шүүхэд бүртгүүлсэн;” гэж өөр хоорондоо зөрчилдсөн хэм хэмжээ бүхий хугацааг тогтоосон байна.

3. Нам, эвслийн сонгуульд оролцох хүсэлтийг Сонгуулийн ерөнхий хороо хүлээн аваад Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.3 дахь хэсэгт заасан шаардлагыг хангаагүй тохиолдолд тухайн нам, эвслийг бүртгэхээс татгалзахаар хуульчилсан байна.

Гэтэл уг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.3 дахь хэсэгт зааснаар сонгууль товлон зарласан өдрөөс хойш буюу сонгуулийн жилийн 02 дугаар сарын 01-ний өдрөөс хойш Улсын дээд шүүхэд бүртгүүлсэн намыг

сонгуульд оролцож, Улсын Их Хурлын гишүүнд нэр дэвшүүлэх эрхгүй байх үр дагаврыг үүсгэхээр байна.

Энэ нь Сонгуулийн ерөнхий хорооны 2020 оны 1/45 дугаар албан бичиг болон Монгол Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгчийн 2020 оны 2788 дугаар албан бичгээр ирүүлсэн болон Үндсэн хуулийн цэцийн хуралдаан дээр гаргасан тайлбарын агуулгаар нотлогдож байна.

4.Монгол Улсын Их Хурлаас 2019 оны 12 дугаар сарын 20-ны өдөр баталсан Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт мөн хуулийн 28 дугаар зүйлийн 28.3.1 дэх заалтад зааснаас өөр хугацаа тогтоосон нь эдгээр зохицуулалтын хэрэгжилтэд тодорхой бус, маргаантай нөхцөл байдлыг үүсгэхээр байна. Энэ нь намаас нэр дэвших иргэний сонгогдох хууль зүйн боломжийг хугацаагаар хязгаарласан байна.

Хууль тогтоогчийн зүгээс энэхүү зөрчилтэй байдлыг залруулах боломж нь Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 82 дугаар зүйлийн 82.1 дэх хэсгийн заалтаар хязгаарлагдсан байх ба Улсын дээд шүүх Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалтын хүрээнд тайлбар хийх замаар шийдвэрлэх боломжгүй байна.

Дээр дурдсан үндэслэл, нөхцөл байдлаас үзэхэд Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэг болон мөн хуулийн 28 дугаар зүйлийн 28.3.1 дэх заалтаар Улсын Их Хурлын сонгуульд оролцох намд өөр өөр шаардлага, шалгуур тогтоосон нь төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц хууль зүйн баталгааг бүрдүүлэх талаарх Үндсэн хуулийн заалтыг зөрчиж, Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажсан иргэний сонгогдох эрхийг хязгаарлах нөхцөлийг үүсгэж байна.

5.Хууль тогтоогчоос сонгуульд оролцох улс төрийн намд тодорхой шалгуурыг хуулийн хүрээнд тогтоож болох боловч уг шалгуур нь үндэслэлтэй, тодорхой, хоёрдмол утгагүй байх ёстой. Ийнхүү тогтоох нь хуульд заасан бусад хугацаа бүхий зохицуулалтуудтай зөрчилдөх, цаашлаад хүний эрх, эрх чөлөөг хөндөж, хязгаарлах нөхцөл бүрдүүлж байгааг тэмдэглэх нь зүйтэй байна.” гээд

Дүгнэлтийн тогтоох хэсэгт:

1.“Монгол Улсын Их Хурлаас 2019 оны 12 дугаар сарын 20-ны өдөр баталсан Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт “Энэ хуульд заасны дагуу сонгууль товлон зарлахаас өмнө Улсын дээд шүүхэд бүртгүүлсэн нам сонгуульд оролцож, энэ хуульд заасан шаардлага хангасан Монгол Улсын иргэнийг Улсын Их Хурлын гишүүнд нэр дэвшүүлэх эрхтэй.” гэж заасны “Энэ хуульд заасны дагуу сонгууль товлон зарлахаас өмнө ...”, мөн хуулийн 28 дугаар зүйлийн 28.3.1 дэх заалтад “Энэ хуульд заасны дагуу нам, эвсэл сонгуульд оролцохоо илэрхийлэх хугацаанаас өмнө Улсын дээд шүүхэд бүртгүүлсэн;”



гэж заасны “Энэ хуульд заасны дагуу нам, эвсэл сонгуульд оролцохоо илэрхийлэх хугацаанаас өмнө ...” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалтад “... сонгогдох эрхтэй. ...”, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц ... хууль зүйн ... баталгааг бүрдүүлэх ... үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

2.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт “Энэ хуульд заасны дагуу сонгууль товлон зарлахаас өмнө Улсын дээд шүүхэд бүртгүүлсэн нам сонгуульд оролцож, энэ хуульд заасан шаардлага хангасан Монгол Улсын иргэнийг Улсын Их Хурлын гишүүнд нэр дэвшүүлэх эрхтэй.” гэж заасны “Энэ хуульд заасны дагуу сонгууль товлон зарлахаас өмнө ...”, мөн хуулийн 28 дугаар зүйлийн 28.3.1 дэх заалтад “Энэ хуульд заасны дагуу нам, эвсэл сонгуульд оролцохоо илэрхийлэх хугацаанаас өмнө Улсын дээд шүүхэд бүртгүүлсэн;” гэж заасны “Энэ хуульд заасны дагуу нам, эвсэл сонгуульд оролцохоо илэрхийлэх хугацаанаас өмнө ...” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 10 дахь заалтад “нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс нам ... байгуулах, сайн дураараа эвлэлдэн нэгдэх эрхтэй. ...” гэж заасныг зөрчөөгүй байна.

3.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт “Энэ хуульд заасны дагуу сонгууль товлон зарлахаас өмнө Улсын дээд шүүхэд бүртгүүлсэн нам сонгуульд оролцож, энэ хуульд заасан шаардлага хангасан Монгол Улсын иргэнийг Улсын Их Хурлын гишүүнд нэр дэвшүүлэх эрхтэй.” гэж заасны “Энэ хуульд заасны дагуу сонгууль товлон зарлахаас өмнө ...” гэснийг, мөн хуулийн 28 дугаар зүйлийн 28.3.1 дэх заалтад “Энэ хуульд заасны дагуу нам, эвсэл сонгуульд оролцохоо илэрхийлэх хугацаанаас өмнө Улсын дээд шүүхэд бүртгүүлсэн;” гэж заасны “Энэ хуульд заасны дагуу нам, эвсэл сонгуульд оролцохоо илэрхийлэх хугацаанаас өмнө ...” гэснийг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу 2020 оны 4 дүгээр сарын 22-ны өдрөөс эхлэн тус тус түдгэлзүүлсүгэй.

4.Энэхүү дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор хэлэлцэж, хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.” гэсэн байна.

Зургаа. Үндсэн хуулийн цэцийн дээрх дүгнэлтийг Улсын Их Хурал 2020 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаараа хэлэлцээд 33 дугаар тогтоолыг гаргасан байна. Үүнд:

“Монгол Улсын Их Хурлаас 2019 оны 12 дугаар сарын 20-ны өдөр баталсан Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 6

дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт “Энэ хуульд заасны дагуу сонгууль товлон зарлахаас өмнө Улсын дээд шүүхэд бүртгүүлсэн нам сонгуульд оролцож, энэ хуульд заасан шаардлага хангасан Монгол Улсын иргэнийг Улсын Их Хурлын гишүүнд нэр дэвшүүлэх эрхтэй.” гэж заасны “Энэ хуульд заасны дагуу сонгууль товлон зарлахаас өмнө ...”, мөн хуулийн 28 дугаар зүйлийн 28.3.1 дэх заалтад “Энэ хуульд заасны дагуу нам, эвсэл сонгуульд оролцохоо илэрхийлэх хугацаанаас өмнө Улсын дээд шүүхэд бүртгүүлсэн;” гэж заасны “Энэ хуульд заасны дагуу нам, эвсэл сонгуульд оролцохоо илэрхийлэх хугацаанаас өмнө ...” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалтад “... сонгогдох эрхтэй. ...”, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц ... хууль зүйн ... баталгааг бүрдүүлэх ... үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.” гэж заасныг тус тус зөрчсөн байна.” гэсэн Үндсэн хуулийн цэцийн 2020 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн 02 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзсүгэй.” гэсэн байна.

Долоо. Монгол Улсын Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Л.Энх-Амгалан Үндсэн хуулийн цэцийн их суудлын хуралдаанд ирүүлсэн тайлбартаа:

“... Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэг, 28 дугаар зүйлийн 28.3.1 дэх заалтын холбогдох хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтуудыг зөрчсөн гэж үзэх үндэслэлгүй байна. Өмнө нь Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанд энэ талаар тайлбар хүргүүлсэн бөгөөд Үндсэн хуулийн цэцийн их суудлын хуралдаанд ч мөн өмнөх тайлбараа баталгаажуулан хүргүүлж байна.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.3 дахь хэсэг нь улс төрийн намыг Улсын дээд шүүхэд бүртгүүлсэн байх хугацааг зөвхөн сонгуульд оролцохоор бүртгүүлэх хүрээнд тавьж буй шаардлага юм. Төрийн үйл хэргийг удирдахад оролцох, төрийн бодлогыг тодорхойлох ажилд оролцохоор сонгуульд өрсөлдөж байгаа улс төрийн нам төрийн сонгуульд оролцох хүсэлтээ илэрхийлэх нь гэнэтийн, тохиолдлын шинжтэй байх нь зохимжгүй бөгөөд бодлого, үзэл баримтлалаа тодорхойлоогүй улс төрийн намыг төрийн сонгуульд оролцоулах нь сөрөг үр дагаврыг бий болгох эрсдэлтэй гэж үздэг.

Улс төрийн намын сонгуулийн мөрийн хөтөлбөрт орсон зорилт, арга хэмжээ нь Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлалд нийцсэн эсэх болон санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын дүн нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан төсвийн тусгай шаардлагад нийцэж байгаа эсэх талаар төрийн аудитын байгууллагаар хянуулж, дүгнэлт гаргуулсан байх хуулийн хугацаа нь тухайн сонгуулийн жилийн 3 дугаар сарын 25-ны өдөр байхаар хуульд заасан. Ийнхүү хөгжлийн үзэл баримтлалд нийцсэн, төсвийн тусгай



шаардлагад нийцэх бодлого тодорхойлох үйл явц нь тодорхой цаг хугацаа шаардах ажил юм.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд заасны дагуу сонгууль товлон зарлахаас өмнө Улсын дээд шүүхэд бүртгүүлсэн нам сонгуульд оролцож, энэ хуульд заасан шаардлага хангасан Монгол Улсын иргэнийг Улсын Их Хурлын гишүүнд нэр дэвшүүлэх эрхтэй байхаар заасан хуулийн заалт нь улс төрийн намын бодлого, хөтөлбөрөө тодорхойлоход, хариуцлагажуулахад чиглэсэн бөгөөд улс төрийн нам нь сонгууль товлон зарлах хугацаанаас өмнө албан ёсоор байгуулагдсан байх шаардлагыг тус хуулиар тогтоосон шаардлагыг хангасан Монгол Улсын иргэнийг нэр дэвшүүлэх шаардлагатай хамт зохицуулж өгсөн. ...

1992 оны Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд улс төрийн намыг санал авах өдрөөс тодорхой хугацааны өмнө сонгуульд оролцохоо Сонгуулийн ерөнхий хороонд бичгээр илэрхийлж, албан ёсоор бүртгүүлэх, 2005, 2011 оны хуульд сонгууль товлон зарласан өдрөөс өмнө Улсын дээд шүүхэд бүртгүүлсэн нам сонгуульд оролцох эрхтэй байхаар зохицуулж ирсэн.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсэгт “Нам, эвсэл Монгол Улсын Үндсэн хууль, энэ хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийг дагаж мөрдөхөө илэрхийлэн, сонгуульд оролцох тухай хүсэлтээ санал авах өдрөөс 60-аас доошгүй хоногийн өмнө Сонгуулийн ерөнхий хороонд ирүүлнэ.” гэж заасан, мөн хуулийн 38 дугаар зүйлийн 38.6 дахь хэсэгт “Нам, эвсэл нь ээлжит сонгуулийн жилийн 3 дугаар сарын 25-ны өдрөөс өмнө ... сонгуулийн мөрийн хөтөлбөртөө дүгнэлт гаргуулахаар төрийн аудитын дээд байгууллагад хүргүүлнэ.” гэж заасан нь улс төрийн намууд сонгуулийн мөрийн хөтөлбөртөө аудитын дүгнэлт гаргуулах хугацаанаас өмнө мөнхүү хөтөлбөрийг бэлтгэх, Улс төрийн намын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь хэсэгт зааснаар сонгуульд оролцох мөрийн хөтөлбөрийг намын эрх бүхий байгууллагаар хэлэлцүүлэн шийдвэрлэхээр заасан нь Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 6.1 дэх хэсэгт заасан хугацааг зайлшгүй шаардаж байгаа юм.

Иймд дээрх зохицуулалт Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалтад “... сонгогдох эрхтэй. ...”, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц ... хууль зүйн ... баталгааг бүрдүүлэх ... үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.” гэж заасныг Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн холбогдох хэсэг, заалт зөрчсөн гэж үзэхгүй байна.” гэсэн байна.

ҮНДЭСЛЭЛ:

1.Монгол Улсын Их Хурлаас 2019 оны 12 дугаар сарын 20-ны өдөр баталсан Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 6

дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт “Энэ хуульд заасны дагуу сонгууль товлон зарлахаас өмнө Улсын дээд шүүхэд бүртгүүлсэн нам сонгуульд оролцож, энэ хуульд заасан шаардлага хангасан Монгол Улсын иргэнийг Улсын Их Хурлын гишүүнд нэр дэвшүүлэх эрхтэй.” гэж заасны “Энэ хуульд заасны дагуу сонгууль товлон зарлахаас өмнө ...”, мөн хуулийн 28 дугаар зүйлийн 28.3.1 дэх заалтад “Энэ хуульд заасны дагуу нам, эвсэл сонгуульд оролцохоо илэрхийлэх хугацаанаас өмнө Улсын дээд шүүхэд бүртгүүлсэн;” гэж заасны “Энэ хуульд заасны дагуу нам, эвсэл сонгуульд оролцохоо илэрхийлэх хугацаанаас өмнө ...” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалтад “... Төрийн байгууллагад ... сонгогдох эрхтэй. ...”, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц ... хууль зүйн ... баталгааг бүрдүүлэх ... үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.” гэж заасныг тус тус зөрчсөн гэсэн Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2020 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн 02 дугаар дүгнэлт үндэслэлтэй байна.

2.Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт “... Улсын Их Хурал дүгнэлтийг хүлээн зөвшөөрөөгүй үндэслэл зөв болох нь нотлогдвол өмнөх дүгнэлтээ хүчингүй болгох, хэрэв үндэслэл нь батлагдахгүй бол Улсын Их Хурлын тогтоолыг хүчингүй болгож тогтоол гаргана.” гэж заажээ. Гэвч Монгол Улсын Их Хурлын 2020 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 33 дугаар тогтоолд Үндсэн хуулийн цэцийн 2020 оны 02 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрөхгүй байгаа үндэслэлээ заагаагүй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйл, Жаран зургадугаар зүйлийн 3, 4 дэх хэсэг, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 2, 32 дугаар зүйлийн 2, 36 дугаар зүйлийн 3, 4 дэх хэсгийн заалтыг тус тус удирдлага болгон

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨӨС ТОГТООХ НЬ:

1.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт “Энэ хуульд заасны дагуу сонгууль товлон зарлахаас өмнө Улсын дээд шүүхэд бүртгүүлсэн нам сонгуульд оролцож, энэ хуульд заасан шаардлага хангасан Монгол Улсын иргэнийг Улсын Их Хурлын гишүүнд нэр дэвшүүлэх эрхтэй.” гэж заасны “Энэ хуульд заасны дагуу сонгууль товлон зарлахаас өмнө ...”, мөн хуулийн 28 дугаар зүйлийн 28.3.1 дэх заалтад “Энэ хуульд заасны дагуу нам, эвсэл сонгуульд оролцохоо илэрхийлэх хугацаанаас өмнө Улсын дээд шүүхэд бүртгүүлсэн;” гэж заасны “Энэ хуульд заасны дагуу нам, эвсэл сонгуульд оролцохоо илэрхийлэх хугацаанаас өмнө ...” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалтад “... Төрийн байгууллагад ... сонгогдох эрхтэй. ...”, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний



эрх, эрх чөлөөг хангахуйц ... хууль зүйн ... баталгааг бүрдүүлэх ... үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.” гэж заасныг тус тус зөрчсөн байх тул хүчингүй болгосугай.

2.Монгол Улсын Их Хурлын 2020 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн “Үндсэн хуулийн цэцийн 2020 оны 02 дугаар дүгнэлтийн тухай” 33 дугаар тогтоолыг хүчингүй болгосугай.

3.Энэхүү тогтоол эцсийн шийдвэр тул гармагцаа хүчин төгөлдөр болохыг дурдсугай.

**ДАРГАЛАГЧ
ГИШҮҮД**

**Н.ЧИНБАТ
Ш.ЦОГТОО
Д.СОЛОНГО
Д.ОДБАЯР
Б.БУЯНДЭЛГЭР
Г.ТУУЛХҮҮ
Ш.СОЛОНГО
Ц.НАНЗАДДОРЖ
Г.БАЯСГАЛАН**

МОНГОЛ УЛС ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ

**(“Улаанбаатар хотын дулаан хангамжийн үр ашгийг нэмэгдүүлэх”
төсөл)**

МОНГОЛ УЛС

болон

ОЛОН УЛСЫН ХӨГЖЛИЙН АССОЦИАЦИ

хоорондын хэлэлцээр

ЗЭЭЛИЙН ДУГААР 6589 -МН

САНХҮҮЖИЛТИЙН ХЭЛЭЛЦЭЭР

Энэхүү ХЭЛЭЛЦЭЭР нь МОНГОЛ УЛС (“Хүлээн авагч”) болон ОЛОН УЛСЫН ХӨГЖЛИЙН АССОЦИАЦИ (“Ассоциаци”) нар гарын үсэг зурсан өдрөөр баталгаажна. Хүлээн авагч болон ассоциаци нь дараах зүйлсийг хэлэлцэн тохиролцов:

I БҮЛЭГ — ЕРӨНХИЙ НӨХЦӨЛҮҮД; НЭР ТОМЬЁОНУУД

- 1.01. Ерөнхий нөхцөлүүд нь (энэхүү Хэлэлцээрийн хавсралтад тусгасан) энэхүү Хэлэлцээрт хүчин төгөлдөр үйлчлэх төдийгүй энэхүү Хэлэлцээрийн салшгүй нэг хэсэг мөн болно.
- 1.02. Хэлэлцээрийн агуулгад өөрөөр заагаагүй бол Хэлэлцээрт том үсгээр тэмдэглэсэн нэр томьёонууд нь Ерөнхий нөхцөлүүд эсвэл Хэлэлцээр, түүний Хавсралтад тайлбарласан утгыг илэрхийлнэ.

II БҮЛЭГ — САНХҮҮЖИЛТ

- 2.01. Ассоциаци нь энэхүү Хэлэлцээрийн Хуваарь 1-т тусгасан төслийг (“Төсөл”) санхүүжүүлэх зорилгоор Ерөнхий нөхцөлүүдийн дагуу хорин есөн сая есөн зуун мянган зээлжих тусгай эрх (ЗТЭ 29,900,000) (өөрөөр “Зээл”, “Санхүүжилт” гэх)-тэй тэнцэх хэмжээний хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтийг Хүлээн авагчид олгохыг хүлээн зөвшөөрч байна.
- 2.02. Хүлээн авагч нь энэхүү Хэлэлцээрийн Хуваарь 2-ийн III хэсэгт заасны дагуу санхүүжилтийн хөрөнгийг зарцуулах боломжтой.
- 2.03. Санхүүжилтийн ашиглагдаагүй үлдэгдэлд тооцогдох хөрөнгийг нөөцлөн баталгаажуулсан хураамжийн дээд хэмжээ жилийн нэг хувийн хагас (1%-ийн 1/2) байна.
- 2.04. Зээлийн ашигласан үлдэгдэлд тооцогдох үйлчилгээний хураамж жилийн нэг хувийн дөрөвний гурав (1%-ийн 3/4) байна.
- 2.05. Зээлийн ашигласан үлдэгдэлд тооцогдох зээлийн хүү жилийн нэг зууны хорин таван хувь (1.25%) байна.
- 2.06. Төлбөр хийх өдөр нь жил бүрийн 6 дугаар сарын 1 болон 12 дугаар сарын 1-ний өдөр байна.
- 2.07. Үндсэн зээлийг энэхүү Хэлэлцээрийн Хуваарь 3-т заасан эргэн төлөгдөх хуваарийн дагуу эргэн төлнө.
- 2.08. Төлбөр гүйцэтгэх мөнгөн тэмдэгт ам.доллар байна.

III БҮЛЭГ — ТӨСӨЛ

- 3.01. Хүлээн авагч төслийн зорилго, зорилтуудыг хангах үүргийг хүлээнэ. Үүнтэй холбогдуулан Хүлээн авагч нь Ерөнхий нөхцөлийн V Бүлэг болон Хэлэлцээрийн Хуваарь 2-т тусгасан заалтуудад нийцүүлэн Төсөл хэрэгжүүлэгч байгууллагаар төслийн хэрэгжилтийг хангуулна.

IV БҮЛЭГ — ХҮЧИН ТӨГӨЛДӨР БОЛОХ; ЦУЦЛАХ

- 4.01. Хүчин төгөлдөр байх хугацааны нэмэлт нөхцөлүүдэд дараах зүйлс багтана:
 - (а) Хүлээн авагч нь Үйл ажиллагааны гарын авлагыг Ассоциацийн шаардлагад нийцэх хэлбэр, агууллагатайгаар баталсан байна;



(Б) Хүлээн авагч нь бүрэн эрх, бүхий бүрэлдэхүүн нэгж, журам бүхий Төслийн удирдах нэгжийг Ассоциацийн шаардлагад нийцэх байдлаар байгуулсан байна.

- 4.02. Хүчин төгөлдөр болох эцсийн хугацаа нь гарын үсэг зурснаас хойш 180 дахь өдөр байх болно.
- 4.03. Ерөнхий нөхцөлүүдийн 10.05 (б)-р Хэсэгт тусгасны дагуу Хүлээн авагчийн Хэлэлцээрийн (төлбөрийн үүрэг, хариуцлагаас бусад) үүрэг хариуцлага нь гарын үсэг зурсан өдрөөс хорин жилийн дараа дуусгавар болно.

V БҮЛЭГ — ТӨЛӨӨЛӨГЧИД; ХОЛБОГДОХ ХАЯГУУД

- 5.01. Хүлээн авагчийг төлөөлөх байгууллага нь тухайн үеийн санхүү хариуцсан яам байх болно.
- 5.02. Ерөнхий нөхцөлүүдийн 11.01-р Хэсэгт заасны дагуу: (а) Хүлээн авагчийн хаяг нь:

Сангийн яам
Засгийн газрын II байр
С. Данзангийн гудамж 5/1 Д
Улаанбаатар 15160
Монгол Улс

ба

(б) Зээлдэгчийн цахим хаяг нь:

Факс:
976-11-320247

- 5.03. Ерөнхий нөхцлүүдийн 11.01-р Хэсэгт заасны дагуу: (а) Ассоциацийн хаяг нь:

Олон улсын хөгжлийн ассоциаци
1818 H Street, N.W.
Вашингтон хот. 20433
АНУ; мөн

(б) Ассоциацийн цахим хаяг нь:

Телекс: Факс:
248423 (МСI) 1-202-477-6391

Хэлэлцээрт гарын үсэг зурсан өдөр ХАРИЛЦАН ТОХИРОЛЦОВ.

МОНГОЛ УЛСЫН ТАЛААС

Гарын үсэг зурсан

Эрх мэдэл бүхий төлөөлөгч

Нэр: _____

Албан тушаал: _____
Огноо: _____

**ОЛОН УЛСЫН ХӨГЖЛИЙН АССОЦИАЦИ-ийн талаас
Гарын үсэг зурсан**

_____ **Эрх мэдэл бүхий төлөөлөгч**
Нэр: _____
Албан тушаал: _____
Огноо: _____

ХУВААРЬ 1

Төслийн танилцуулга

Төслийн зорилго нь сонгосон Төслийн талбайд дулааны сүлжээний хүчин чадлыг тэлж, үр ашигтай байдлыг нь сайжруулахад оршино.

Төсөл нь дараах хэсгүүдээс бүрдэнэ:

1-р Хэсэг: Дулааны сүлжээг Сэргээн засварлах, Өргөтгөх

УБДС-ний дулааны системд нэн шаардлагатай байгаа хөрөнгө оруулалтыг боловсруулж, хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. Үүнд:

- 1.1. Ашиглалтад байгаа сонгосон дамжуулах хоолойнуудыг шинээр солих замаар одоо байгаа сонгогдсон хэсгүүдэд дулаан хангамжийн сүлжээг сэргээн засварлаж, өргөтгөх.
- 1.2. Дамжуулах хоолойг сунгаж, шинээр суурилуулах замаар дулааны сүлжээг гэр хорооллын сонгосон хэсгүүдэд тэлэх.
- 1.3. Ухаалаг өргөлтийн шахуурга болон/эсвэл дулаан солилцууртай сонгосон дамжуулах хоолойнуудыг шинээр солих замаар дулааны насос станцуудыг шинэчлэх.

2-р Хэсэг: Чадавхыг бэхжүүлэх, Төслийн хэрэгжилтийг дэмжих

Дараах зорилгоор техник, үйл ажиллагааны дэмжлэг үзүүлнэ:

- 2.1. УБДС-ний үйл ажиллагаа, хариуцлагыг бэхжүүлж, салбарын төлөвлөлт, дүрэм журам, байгууллагын зохицуулалт зэрэгт гол оролцогч талуудын чадавхыг сайжруулах;
- 2.2. Төлөвлөлт, гүйцэтгэл, худалдан авах ажиллагаа, санхүүгийн удирдлага, нийгэм болон байгаль орчны эрсдэлээс хамгаалах менежмент, хяналт, үнэлгээ зэргийг оруулаад төслийн хэрэгжилтийг хангах.



ХУВААРЬ 2

Төслийн гүйцэтгэл

1-р Хэсэг. Хэрэгжилтийн зохицуулалтууд

А. Байгууллагын зохицуулалт.

1. Хүлээн авагч нь Төсөл хэрэгжих хугацаанд үндэсний болон орон нутгийн хэмжээнд Төслийн хэрэгжилт хариуцсан нэгжүүдийг ажиллуулж, Ассоциаци болон Үйл ажиллагааны гарын авлагад тусгасан шаардлагад нийцсэн бүрэлдэхүүн, үйл ажиллагаа, ажиллах хүчин, нөөц бололцоогоор хангана.
2. Өмнө дурдсан хязгаарлалтуудаас үл хамааран Хүлээн авагч нь Эрчим хүчний яаманд: (а) Төслийн удирдах нэгжийг байгуулж, Төслийн өдөр тутмын ерөнхий хэрэгжилт болон холбогдох бусад ажлыг хариуцуулна, үүнд : (i) Жилийн төлөвлөлт, төсөв хуваарилалт, (ii) худалдан авах ажиллагаа, санхүүгийн удирдлага, байгаль орчин, нийгмийн эрсдэлээс хамгаалах менежмент, (iii) Төслийн хяналт, дүгнэлт; мөн (iv) Төслийн хэрэгжилтийн явцад холбогдох техникийн асуудлаар УБДС-тэй холбоотой ажиллах; (б) Төслийн хэрэгжилтэд техникийн дэмжлэг үзүүлэх зорилгоор Хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 3 (гурван) сарын дотор Ассоциацийн шаардлагад нийцсэн техникийн ажлын хэсгийг УБДС-ээр байгуулуулж, хариуцуулж ажиллана.

Б. Дамжуулан зээлдүүлэх гэрээ

1. Хүлээн авагч нь Ассоциацид хүлээн зөвшөөрөгдсөн нөхцөлөөр СЯ болон УБДС хооронд байгуулсан Дамжуулан зээлдүүлэх гэрээнд заасны дагуу Төслийн 1-р хэсгийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд санхүүжилтийн тодорхой хэсгийг УБДС-д олгоно. Дамжуулан зээлдүүлэх гэрээний нөхцөлд дараах зүйлсийг хамруулна:
 - (а) Санхүүжилтийн зардлаас санхүүжих эрхтэй Дэд төслийн ажлууд, тэдгээрийн зарцуулалтын дэлгэрэнгүй тайлбар;
 - (б) УБДС-ний хүлээх үүрэг:
 - (i) Төслийн 1-р хэсэгт заасан ажлуудыг холбогдох техник, эдийн засаг, санхүү, удирдлагын туршлагад үндэслэн хугацаанд нь үр дүнтэй хийж гүйцэтгэнэ. Үүнд Хүлээн авагчаас бусад санхүүжилт авч буй талуудад хамаарагдах Үйл ажиллагааны гарын авлага, Байгаль орчин, нийгмийн хамгааллын удирдлагын төлөвлөгөө Авлигын эсрэг зөвлөмж багтана.
 - (ii) Дэд төслүүдийг хэрэгжүүлэхэд шаардагдах нөөцийг тухай бүрд нь хангаж, хангуулж ажиллана;
 - (iii) зээлийн санхүүжилтээр авч буй бараа бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээг Худалдан авах ажиллагааны журам, Үйл ажиллагааны гарын авлагад нийцүүлэх;

- (iv) Төслийн 1 дүгээр хэсгийн ажлууд болон зорилтуудын гүйцэтгэлийг Ассоциацийн шаардлагад нийцэх үзүүлэлтүүдийн дагуу хяналт тавьж, дүгнэлт хийх;
 - (v) (А) Үйл ажиллагааны гарын авлагын заалтуудын дагуу санхүүгийн удирдлагын шаардлагуудыг биелүүлэх;
(Б) Хүлээн авагч эсхүл Ассоциацийн хүсэлтийн дагуу Ассоциацийн хүлээн зөвшөөрдөг аудитын стандартын дагуу Ассоциацийн хүлээн зөвшөөрсөн хараат бус аудитын компаниар санхүүгийн тайланд аудит хийлгэж зохих журмын дагуу Хүлээн авагч болон Ассоциацид санхүүгийн тайланг хүргүүлэх;
 - (vi) Төслийн 1 дүгээр хэсгийн ажлууд болон холбогдох бүх бүртгэл, баримт бичгүүдийг Хүлээн авагч болон Ассоциаци шалгах боломжтой байлгах;
 - (vii) Дээр дурдсан зүйлстэй холбоотойгоор Хүлээн авагч эсвэл Ассоциацийн гаргасан хүсэлтийн дагуу бүх мэдээллийг Хүлээн авагч болон Ассоциацид боловсруулж, боловсруулуулж ажиллана;
- (в) Хэрэв УБДС нь Дамжуулан зээлдүүлэх гэрээнд хүлээсэн үүрэг хариуцлагаа биелүүлээгүй тохиолдолд Хүлээн авагч нь СЯ-аар дамжуулан УБДС-ний санхүүжилтийн эрхийг хаах, цуцлах, аль эсвэл санхүүжилтийг олгосон тохиолдолд бүхлээр нь эсвэл хэсэгчлэн нөхөн төлүүлэх эрхтэй.
2. Хүлээн авагч нь СЯ-аар дамжуулан холбогдох эрхээ эдэлж, Хүлээн авагч болон Ассоциацийн эрх ашгийг хамгаалах, Санхүүжилтийн зорилтуудыг гүйцэлдүүлэх зорилгоор Дамжуулан зээлдүүлэх гэрээний үүрэг хариуцлагаа биелүүлнэ. Ассоциаци хүлээн зөвшөөрөөгүй тохиолдолд Хүлээн авагч нь Дамжуулан зээлдүүлэх гэрээ, түүний аливаа заалтыг шинээр нэмэх, өөрчлөх, цуцлах, хойшлуулах ёсгүй.
- В. Үйл ажиллагааны гарын авлага**
- Хүлээн авагч нь Үйл ажиллагааны гарын авлагад тусгасан арга хэмжээ, журмын дагуу Төслийг хэрэгжүүлэхэд анхаарч ажиллах (Үйл ажиллагааны гарын авлага арга хэмжээ, журмууд энэхүү Хэлэлцээрийн заалтуудтай зөрчилдсөн тохиолдолд энэхүү Хэлэлцээрийн заалтууд давуу үйлчилнэ) бөгөөд Ассоциаци татгалзах зүйлгүй гэдгээ албан бичгээр хүргүүлээгүй тохиолдолд Үйл ажиллагааны гарын авлагын ямар ч заалтуудыг өөрчлөх, цуцлах, эсвэл хойшлуулах ёсгүй.
- Г. Байгаль орчин, нийгмийн стандарт**
1. Хүлээн авагч нь Төслийг Ассоциацийн шаардлагад нийцэх Байгаль орчин, нийгмийн стандартын хүрээнд хэрэгжүүлэхэд анхаарна.
2. Дээрх 1-р заалтын хязгаарлалтаас үл хамааран Хүлээн авагч нь Ассоциацийн шаардлагад нийцүүлэх Байгаль орчин, нийгмийн хамгааллын удирдлагын төлөвлөгөөний (БОНХУТ) хүрээнд Төслийг



хэрэгжүүлэхэд анхаарна. Энэ хүрээнд Хүлээн авагч нь дараах зүйлсийг хангаж ажиллана:

- (а) БОНХУТ-нд тусгасан арга хэмжээ, үйл ажиллагааг БОНХУТ-нд заасны дагуу хугацаанд нь, үр дүнтэй хэрэгжүүлэх;
 - (б) БОНХУТ-ийг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг бүрэн хангах санхүүжилтийг бэлэн байлгах;
 - (в) БОНХУТ-ийг хэрэгжүүлэхэд шаардагдах бодлого, журам, шаардлага хангасан ажиллах хүчний бүрэлдэхүүнийг БОНХУТ-д заасны дагуу хангах;
 - (г) Ассоциаци бичмэл байдлаар зөвшөөрөөгүй тохиолдолд Хүлээн авагч нь БОНХУТ-ийн аливаа заалтыг өөрчилж, шинэчилж, хойшлуулахгүй бөгөөд Ассоциаци зөвшөөрсөн тохиолдолд Хүлээн авагч нь шинэчилсэн БОНХУТ-ийг танилцуулна.
3. БОНХУТ-ний заалтууд энэхүү Хэлэлцээрийн заалтуудтай зөрчилдөх тохиолдолд энэхүү Хэлэлцээрийн заалтууд давуу үйлчилнэ.
4. Хүлээн авагч нь:
- (а) БОНХУТ-нд заасан давтамжийн дагуу Ассоциацид тогтмол тайлагнах зорилгоор мэдээллийг цуглуулах, нэгтгэх, боловсруулахад шаардлагатай бүх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Мөн Ассоциацийн хүсэлтийн дагуу БОНХУТ-ний хэрэгжилтийн явц, менежмент, болон бусад холбогдох мэдээллийг тухай бүрд нь Ассоциацийн шаардлагад нийцэх хэлбэр, агуулгатайгаар тайлагнана. Үүнд: (i) БОНХУТ-ний хэрэгжилтийн байдал; (ii) БОНХУТ-ний хэрэгжилтэд саад болох эсвэл саад болох магадлалтай нөхцөлүүд; (iii) тэдгээр нөхцөлүүдийг шийдвэрлэхэд шаардлагатай засаж, залруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүд;
 - (б) Төсөлтэй холбоотойгоор, эсвэл төслийн нөлөөгөөр байгаль орчин, оршин суугчид, олон нийт, ажилчдад сөргөөр нөлөөлөх ямар нэг осол гарсан тохиолдолд БОНХУТ-нд заасан хэрэглүүрүүд болон Байгаль орчин, нийгмийн стандартын дагуу Ассоциацид яаралтай мэдэгдэнэ.
5. Хүлээн авагч нь Төсөлтэй холбоотой бүх гомдлыг сонсож, шударгаар шийдвэрлэх зорилгоор гомдол хүлээн авах механизмыг Ассоциацийн шаардлагад нийцэх байдлаар нээлттэй байлгаж, олон нийтэд сурталчилж ажиллана. Гомдол хүлээн авах механизмаар ирүүлсэн гомдлыг шийдвэрлэхэд шаардлагатай бүх арга хэмжээг авч хэрэгжүүлэх бөгөөд ингэхдээ Ассоциацийн шаардлагад нийцэх байдлаар хэрэгжүүлнэ.

2-р Хэсэг. Төслийн хяналт-шинжилгээ, тайлагнал ба үнэлгээ

А. Төслийн тайлангууд

Хүлээн авагч нь тухайн улирлыг хамарсан Төслийн тайлан хуанлийн улирал дууссанаас хойш дөчин тав (45) хоногийн дотор Ассоциацид хүргүүлнэ.

Б. Дунд хугацааны үнэлгээ

Хүлээн авагч нь: (а) хэлэлцээр Хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш гучин (30) сарын дотор төслийн хэрэгжилтийн явцад гарсан ахиц дэвшил, дээр дурдсан А Хэсэгт тусгасан хяналт-шинжилгээ, үнэлгээ болон Төслийг цаашид үр дүнтэй үргэлжлүүлэхэд авч хэрэгжүүлэх зохистой үйл ажиллагааны зөвлөмж, төлөвлөсөн зорилтуудын хэрэгжилтийн талаар Ассоциацийн хүсэлтэд тусгасан нарийвчлалтайгаар дунд хугацааны тайлан боловсруулж, Ассоциацид өргөн барина. Ингэхдээ тайлан танилцуулах өдөр хүртэлх үйл ажиллагааг бүрэн хамарна; (б) дунд хугацааны тайланг өргөн барьснаас хойш дөчин тав (45) хоногийн дотор Ассоциацитай хамтран үнэлгээ гаргана. Дунд хугацааны тайлангийн дүгнэлт, зөвлөмж болон тухайн асуудлууд дээрх Ассоциацийн байр суурьт үндэслэн, Төслийг үр ашигтай үргэлжлүүлж, зорилтуудыг нь биелүүлэхэд шаардагдах бүх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

3-р Хэсэг. Санхүүжилтийн хөрөнгийг зарцуулах үйл явц

А. Ерөнхий зүйл

Хүлээн авагч нь Ерөнхий нөхцөлүүдийн 2-р Хэсэг болон Ассоциацаас Хүлээн авагчид хүргүүлэх Зарцуулалтын болон санхүүгийн мэдээллийн албан захидлаас үл хамаарч, бараа бүтээгдэхүүн, ажил үйлчилгээ, зөвлөх, зөвлөхийн бус үйлчилгээ, Сургалтын болон Үйл ажиллагааны Зөвшөөрөгдсөн зардлыг санхүүжилтийн хөрөнгөөс 100% санхүүжүүлж болно. Үүнд татварыг тооцсон байна.

Б. Хөрөнгө зарцуулах нөхцөлүүд; Хугацаа

1. Дээр дурдсан А хэсгийн заалтаас үл хамаарч энэхүү Хэлэлцээрийг байгуулсан өдрөөс өмнө гарсан аливаа төлбөрт зориулж зарцуулалт хийхгүй. Харин гарын үсэг зурахаар товлосон өдрөөс арван хоёр (12) сарын өмнө буюу 2019 оны 8 дугаар сарын 1-ний өдөр эсхүл түүнээс хойш гүйцэтгэсэн, нийт дүн нь 5,980,000 ЗТЭ-ээс хэтрэхгүй зөвшөөрөгдсөн зардлуудыг нөхөн санхүүжүүлнэ.
2. Төсөл дуусгавар болох өдөр 2025 оны 12 дугаар сарын 31 байна.

ХУВААРЬ 3

Эргэн төлөлтийн хуваарь

Төлбөр хийх огноо	Эргэн төлөх зээлийн үндсэн хэмжээ (хувиар илэрхийлэв)*
Жил бүрийн 6 дугаар сарын 1 ба 12 дугаар сарын 1	
2025 оны 6 дугаар сарын 1 өдрөөс эхлэн 2044 оны 12 дугаар сарын 1 өдрийг хүртэл (тухайн өдрийг оролцуулаад)	1.65%



2045 оны 6 дугаар сарын 1 өдрөөс эхлэн 2049 оны 12 дугаар сарын 1 өдрийг хүртэл (тухайн өдрийг оролцуулаад)	3.40%
---	-------

* Ерөнхий нөхцөлүүдийн 3.05 (б) хэсэгт заасны дагуу Ассоциациас өөрөөр заагаагүй бол дээрх хувь хэмжээ нь эргэн төлөгдөх үндсэн зээлийн хувь хэмжээг илэрхийлнэ.

ХАВСРАЛТ

Нэр томьёо

1. “Авилгын эсрэг журам” гэж Ерөнхий нөхцөлүүдийн Хавсралт дахь 5 дугаар хэсгийг хэрэгжүүлэхэд ашиглах, 2006 оны 10 дугаар сарын 15-нд баталж, 2011 оны 1 дүгээр сарын 1-нд болон 2016 оны 7 дугаар сарын 1-нд тус тус шинэчилсэн “Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банк (ОУСБХБ)-ны зээл болон Олон улсын хөгжлийн ассоциаци (ОУХА)-ийн хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламжийн санхүүжилт бүхий төслүүдэд ашиглагдах залилан, авилгаас урьдчилан сэргийлэх журам”-ыг хэлнэ.
2. “Байгаль орчин, нийгмийн хамгааллын удирдлагын төлөвлөгөө” буюу “БОНХУТ” гэх товчлол нь Хүлээн авагчийн зүгээс Хамгааллын бодлогод нийцүүлэн боловсруулж, Ассоциацийн зөвшөөрлийг үндэслэн 2020 оны 3 дугаар сарын 11-ний өдөр олон нийтэд нээлттэй болгосон төлөвлөгөөг хэлнэ. Төслийн улмаас байгаль орчин, нийгмийн болзошгүй эрсдэл, нөлөөллийг шийдвэрлэх материаллаг арга хэмжээ, ажлуудыг Төлөвлөгөөнд тоймлосон болно. Үүнд тэдгээр арга хэмжээ, ажлуудын цаг хугацаа болон байгууллага, ажилчид, сургалт, хяналт, тайлагналтын зохицуулалтууд багтана. Мөн Ассоциацийн бичгээр хүргүүлсэн зөвшөөрлийн дагуу БОНХУТ-ийг шинэчлэх боломжтой тул цаашид тэдгээрт зориулан боловсруулах баримт бичгүүдийг хамруулна. Эдгээр нөхцөлд төслийн холбогдох бүх хавсралт, хуваариуд багтана.
3. “Байгаль орчин, нийгмийн стандарт” гэж дараах зүйлсийг хэлнэ. Үүнд: (i) “Байгаль орчин, нийгмийн стандарт 1: Байгаль орчин, нийгмийн эрсдэл, нөлөөллийн үнэлгээ, удирдлага”; (ii) “Байгаль орчин, нийгмийн стандарт 2: Хөдөлмөр, ажлын нөхцөл”; (iii) “Байгаль орчин, нийгмийн стандарт 3: Нөөцийн үр ашигтай зарцуулалт, бохирдлыг бууруулах, зохицуулах”; (iv) “Байгаль орчин, нийгмийн стандарт 4: Нийгмийн эрүүл мэнд, аюулгүй байдал”; (v) “Байгаль орчин, нийгмийн стандарт 5: Газар чөлөөлт, газар ашиглалтын хязгаарлалт, албадан нүүлгэн шилжүүлэлт”; (vi) “Байгаль орчин, нийгмийн стандарт 6: Био төрөл зүйлийг хамгаалах, байгалийн амьтай нөөцийн тогтвортой удирдлага”; (vii) “Байгаль орчин, нийгмийн стандарт 7: Уугуул иргэд/Түүхэнд хадгалагдаагүй сахарын уламжлалт уугуул иргэд”; (viii) “Байгаль орчин, нийгмийн стандарт 8: Соёлын өв”; (ix) “Байгаль орчин, нийгмийн стандарт 9: Санхүүгийн зуучлалт”; (x) “Байгаль орчин, нийгмийн стандарт 10: Оролцогч талуудын үүрэг оролцоо,

мэдээллийг олон нийтэд түгээх”; ассоциацийн <https://www.worldbank.org/en/projects-operations/environmental-and-social-framework> хаягт нийтэлсний дагуу 2018 оны 10 дугаар сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр болсон.

4. “Ерөнхий нөхцөлүүд” гэж 2018 оны 12 дугаар сарын 14-ний өдөр батлагдсан “Олон улсын хөгжлийн ассоциацийн хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламжийн Ерөнхий нөхцөлүүд”-ийг хэлнэ.
5. “Гэр хороолол” гэж Хүлээн авагчийн Улаанбаатар хотын захын хорооллуудыг хэлнэ.
6. “ЭХЯ” гэдэг нь Хүлээн авагчийн Эрчим хүчний яам болон тус байгууллагыг цаашид орлох байгууллагуудыг хэлнэ.
7. “СЯ” гэдэг нь Хүлээн авагчийн Сангийн Яам болон тус байгууллагыг цаашид орлох байгууллагуудыг хэлнэ.
8. “Үйл ажиллагааны зардал” гэдэг нь Төслийн үйл ажиллагаанд өдөр тутам явуулах зохицуулалт, удирдлага, хяналтын ажилд шаардагдах бараа бүтээгдэхүүн, зөвлөхийн бус үйлчилгээний боломжит зардлыг хэлэх бөгөөд үүнд тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, барилга, байгууламж, албан газрын лизинг, засвар, үйлчилгээ, түлш, албан газрын хангамж, хэрэгсэл, харилцаа холбооны зардал (үүнд шуудан, үүрэн холбоо, интернетийн зардал багтана), тээвэрлэлт, орчуулга, хэвлэл, фото хэвлэл, банкны төлбөр, хэвлэл мэдээлэл, сурталчилгаа, даатгал, Төсөлтэй холбоотой уулзалт, томилт, тэдгээрийн байрлах газар, гэрээт туслах ажилтнууд болон Төсөлтэй шууд холбогдох бусад захиргааны зардлыг хамруулах бөгөөд Хүлээн авагчийн төрийн үйлчилгээний гишүүдийн цалин хөлс, нэмэлт цалин, төлбөр зэргийг тооцохгүй.
9. “Үйл ажиллагааны гарын авлага” гэж энэхүү Хэлэлцээрийн Хуваарь 2-ийн 1.Б Хэсэгт заасан Төслийн хэрэгжилтэд зориулж Хүлээн авагчийн боловсруулах гарын авлагыг хэлэх бөгөөд дараах зорилгын хүрээнд нарийвчилсан зохицуулалт, журмуудыг агуулсан болно. Үүнд: (а) байгууллагын зохицуулалт, Төслийн хүрээнд өдөр тутамд гүйцэтгэх ажил; (б) зарцуулалт, санхүүгийн удирдлага; (в) худалдан авах ажиллагаа, (г) байгаль орчин, нийгмийн хамгааллын арга хэмжээ; (д) хяналт, үнэлгээ, тайлан, харилцаа холбоо; (е) нэгдсэн үйл ажиллагааны төлөвлөгөө, (ё) Төслийн 1-р Хэсэгт заасан зарим ажлыг тодорхойлж, үнэлж, хэрэгжүүлэхэд зориулсан зөвшөөрөгдөх шалгуур үзүүлэлт, нарийвчилсан зохицуулалт, журмууд (ж) Төслийн хүрээнд шаардагдах бусад удирдлага, санхүү, техник, байгууллагын зохицуулалт, журмууд; дурдсан гарын авлагыг Ассоциацийн бичгээр хүргүүлсэн зөвшөөрлийн дагуу өөрчлөх боломжтой бөгөөд тухайн гарын авлагын хуваарийг тухай бүрд нь нэгтгэнэ.
10. “Худалдан авах ажиллагааны журам” гэж Ерөнхий нөхцөлүүдийн Хавсралт дахь 87 дугаар хэсэгт зааснаар 2016 оны 7 дугаар сард баталж, 2017 оны 11 дүгээр болон 2018 оны 8 дугаар сард тус тус



шинэчилсэн “Хөрөнгө оруулалтын төслийн санхүүжилтийн зээлдэгч нарт зориулсан Дэлхийн банкны Худалдан авах ажиллагааны журам”-ыг хэлнэ.

11. “Төслийн талбай” гэж Хүлээн авагчийн Ассоциацитай зөвшилцөж сонгосон Улаанбаатар хот дахь талбайг хэлнэ.
12. “Төслийн удирдах нэгж” гэж энэхүү Хэлэлцээрийн Хуваарь 2 -ийн I.A хэсгийн 2 дүгээр заалт болон үүнийг орлох баримт бичигт тусгасан Хүлээн авагчийн байгуулсан нэгжийг хэлнэ.
13. “Гарын үсэг зурсан өдөр” гэж энэхүү Хэлэлцээрт Ассоциаци болон Хүлээн авагч тал харилцан гарын үсэг зурсан хоёр өдрийн сүүлийнхийг нь хэлэх бөгөөд энэхүү тодорхойлолт нь Ерөнхий нөхцөлүүдэд тусгагдсан “Санхүүжилтийн хэлэлцээрийн огноо” гэсэн нэр томъёонд мөн хамаарна.
14. “Дэд-төсөл” гэж Санхүүжилтийн хөрөнгөөс санхүүжих Төслийн 1-р хэсэгт заасан багц арга хэмжээнүүдийг хэлэх бөгөөд “Дэд-төсөл” гэх тодорхойлолтод бүх Дэд-төслүүд багтана.
15. “Сургалт” гэж Төслийн хүрээнд явуулах сургалт, семинар, сургах аялалд хамаарагдах ажилчдын оролцооноос үүдэн гарах бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний зардлыг хэлнэ. Үүнд тээврийн болон сургалт, семинар, сургах аяллын дагалдах зардлууд, сургагчдын үйлчилгээг хангах зардал, сургалт, семинарын явуулах байгууламжийн түрээс, сургалтын материалууд боловсруулах, дахин хэвлэх зардал болон бусад шууд бус зардлууд хамаарагдана. Хүлээн авагчийн төрийн үйлчилгээний зөвлөхүүдийн цалин хөлс, нэмэлт, төлбөр, урамшуулал болон түүнтэй дүйцэх төлбөрийг үүнд тооцохгүй.
16. “УБДС” гэж Монгол Улсын Засгийн газрын 2001 оны 7 дугаар сарын 9-ний өдрийн 164-р тогтоолоор байгуулагдаж, Хүлээн авагчийн холбогдох хууль дор үйл ажиллагаа явуулж байгаа Улаанбаатар Дулааны Сүлжээ ТӨХК болон цаашид түүнийг орлох байгууллагыг хэлнэ; мөн Ерөнхий нөхцөл, “Төслийг хэрэгжүүлэх нэгж”-ийн хүрээнд.

Хаяг:

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакц.
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот
И-мэйл: turiin_medeel@parliament.mn

Утас: 262420

Хэвлэлийн хуудас: 2.25

Индекс: 200003